



**БУЛГАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 25 өдөр

Дугаар IV/25

Булган сум

**Аймгийн Засаг даргын
2024-2028 оны үйл ажиллагааны
“Булганы сэргэлт” хөтөлбөрийг батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5, 35.1.8, 48 дугаар зүйлийн 48.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ес дэх удаагийн сонгуулийн IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2024-2028 оны “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтыг 1 дүгээр хавсралтаар, хяналт, шинжилгээ, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Аймгийн Засаг даргын 2024-2028 оны “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга (Д.Пүрэв-Очир)-д даалгасугай. Үүнд

2.1.Аймгийн Засаг даргын 2024-2028 оны “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилтыг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, улс, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх;

2.2.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжүүлж ажиллах;

2.3.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газар, яам, агентлаг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй нягт хамтран ажиллах;

2.4.Хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний биелэлтийг хагас жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба (О.Наранжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.НАСАНДУЛАМ

